

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	2
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ХЗДХЯ	Хууль зүйн дотоод хэргийн яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАР ИВЭЭЛ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ ХОШУУЧ Г.ЭНХБАЯР
ТАНАА

2020.03.13 № 06/850
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Газар ивээл ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал хошууч Г.Энхбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтдаа үйл ажиллагааны онцлогтоо тохирсон зүйл заалтуудыг нэмж оруулах, анхан шатны бүрдлийг хангасан баримтыг үндэслэн ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгах, мөнгөн кассын тооллого сар бүр хийж хэвших зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Газар ивээл ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 09-нээс 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төрийн өмчит үйлдвэрийн газарт хүргүүлэхээр төлөвлөн, “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн анхан шатны чанарын хяналтыг захирал Ж.Цэцэгмаа, аудитор Б.Мягмар, аудиторын туслахаар Г.Ундармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/19 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АОУС, АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Газар ивээл ТӨААТҮГ нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “ШШГЕГ-ын хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудыг тус үйлдвэрт ажиллуулснаар улсад болон иргэнд учруулсан гэм хорыг ажлын хөлсөөр нь барагдуулах болон арьсан эдлэл хийх арга барилд сургаж, хоригдох хугацаанд нь хөдөлмөр эрхлүүлэн нийгэмшүүлэх” гэж тодорхойлсон.

Газар ивээл ТӨААТҮГ-ын тайлант оны зорилт нь бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чандлан сахих. Үүнд:

- Ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу гутал, арьсан эдлэл үйлдвэрлэж хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн албан хаагч, хоригдол, хоригдогсдын хэрэгцээнд нийлүүлэх;
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа хуулийн этгээдийн дүрэмт хувцасны гутал, ажлын гутал, тэлээ, бүс, бусад арьсан эдлэл үйлдвэрлэн нийлүүлэх
- Байгууллагын албан хаагч, ажиллагсад, бусад захиалагчийн хэрэгцээнд чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан борлуулах;
- Техник, технологийн дэвшил нэвтрүүлэх, тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох;
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 тоот “Журам батлах тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол
- ХЗДХЯ-ны сайдын 2019 оны 4 дүгээр сарын 4-ний А/52 тоот тушаалаар баталсан “ШШГБ-ын албан хаагчын хэрэглэх тусгай техник хэрэгсэл, галт зэвсэг сум бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Газар ивээл ТӨААТҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа ШШГЕГ -ын хэмжээнд хийгдсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн боловч Газар ивээл ТӨААТҮГ-ын өөрийн үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй байна.

Газар ивээл ТӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Газар ивээл ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Газар ивээл ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд 7 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АОУС 320, АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг **дунд** гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 189.1 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцон 3.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18.2 сая төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	69.6	126.9	57.3
Авлага	0.2	0.9	0.7
Бараа материал	26.6	31.3	4.7
Үндсэн хөрөнгө	265.5	221.0	(44.5)
Нийт хөрөнгө	361.9	380.1	18.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	209.6	209.6	-
Хуримтлагдсан ашиг	150.4	168.6	18.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	361.9	380.1	18.2

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 57.3 сая төгрөгөөр өмнөх оноос өссөн нь борлуулалтын орлого өссөнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь хувь хүнээс авах 0.6 сая төгрөгийн авлага, мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын авлага 0.3 сая төгрөг тайлант оны эцэст үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Хувь хүнээс авах авлага 0.6 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар, 0.3 сая төгрөгийг Баянзүрх дүүргийн татварын хэлтэстэй тооцоо хийж тус тус баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үйлдвэрлэл нэмэгдэж, худалдан авалт өссөнөөс шалтгаалжээ. Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөцийн үлдэгдэл 4.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өртөг буурсан нь тайлант хугацааны элэгдлээс шалтгаалсан.

Тайлант онд 45.2 сая төгрөг үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан, ШШГЕГ-аас 1.5 сая төгрөгийн компьютер, бусад хэрэгсэл үнэ төлбөргүйгээр авч үндсэн хөрөнгө дансанд тусгасан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл өртөг буурсан нь тайлант хугацаанд биет бус хөрөнгийн элэгдлийг 0.9 сая төгрөгөөр байгуулсантай холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй.

2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн тодруулга

Засгийн газрын 2016 оны 28 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм”-ын 1.2-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар нь энэ тогтоолын 5 дугаар зүйлийн 5.1-д заасан чиглэлийг мөрддөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Газар ивээл ТӨААҮГ нь ШШГЕГ-ын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/232 тоот тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 2019 онд 702.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 134.5 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллана гэсэн гэрээтэй байна.

Тус газар нь ШШГЕГ-ын харьяа газруудад ажлын гутал, арьсан эдлэл, зөөлөн эдлэл үйлдвэрлэн 736.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан. Борлуулалттай уялдан борлуулсан барааны өртөг 531.2 сая төгрөг болж, борлуулалтын ашиг 204.9 сая төгрөг байна.

Мөн тайлант онд Газар Ивээл ТӨААҮҮГ нь шинээр зөөлөн эдлэлийн тасгийг байгуулан, туршилтын журмаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж ажилласан байна.

Зорилтот түвшин дэх борлуулалтын болон удирдлагын зардлын гүйцэтгэлийн талаарх тодруулга:

Хүснэгт 2. Борлуулалтын болон удирдлагын зардлын гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт борлуулалт	702.0	736.2	34.2	104.9
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	494.1	531.2	37.1	107.5
Нийт ашиг	207.9	205.0	-2.9	98.6
Нийт Удирдлагын зардал:	73.4	76.1	2.7	103.7
Үүнээс Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	48.3	49.3	1.0	102.0
Бараа үйлчилгээний бусад зардал	17.2	26.8	9.6	155.0
Хөрөнгө оруулалтын зардал	2.8	-		
Нөөцийн сан	5.0	-		

Борлуулалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд анхааран ажилласны үр дүнд борлуулалтын хэмжээг 34.2 сая төгрөгөөр буюу 104.9 хувиар нэмэгдүүлжээ.

Тайлант онд ШШГЕГ-аас Удирдлагын зардлын төсвийг 2.7 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар хэтрүүлсэн. Энэ нь 2019 онд үндсэн цалингийн сүлжээнд нэмэлт өөрчлөлт орсон мөн бараа үйлчилгээний зардалд үндсэн хөрөнгийн элэгдэл 15.7 сая төгрөг байгаатай холбоотой байна.

ШШГЕГ-аас баталж өгсөн Удирдлагын зардлын 73.4 сая төгрөгийн төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг тусгаагүй байна.

Тайланд онд баталсан хуваарийн дагуу 100.0 сая төгрөгийг ШШГЕГ-т хугацаанд нь төвлөрүүлж шилжүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэлгүй гэж тодорхойлон нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Газар ивээл ТӨААҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Газар ивээл ТӨААҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Газар ивээл ТӨААҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, дүрэм, журам СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Газар ивээл ТӨААҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа ШШГЕГ -ын хэмжээнд хийгдсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн боловч Газар ивээл ТӨААҮГ-ын өөрийн үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бүртгэл тайлан алдаатай илэрхийлэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Байгууллагынхаа онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: ШШГЕГ-аас 2020 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж гаргана гэсэн хариу өгсөн.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Сар бүр эсгүүрийн цехээс оёдлын цехэд, оёдлын цехээс бэлэн бүтээгдэхүүний тасагт шилжсэн үйлдвэрлэлийн дамжлагын бүртгэл хөтөлж, тайлан гаргаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4."Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл,

үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Бараа материалд бүртгэлээр тавих хяналт суларч бэлэн бүтээгдэхүүн, бараа материал алдагдах, дутагдах;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Үйлдвэрийн цех хариуцсан технологич, мастерууд сар бүр дамжлагын ажил, орц, гарцын бүртгэл хөтөлж, материалын тайланг гаргаж нягтлан бодогчид хүлээлгэн өгч байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цех хоорондын дамжлагын маягт бүртгэлийг гаргаж, хөтлүүлж хэвшиж байна.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Мөнгөн кассын тайлангийн үлдээдлийн тооллого сар бүр хийгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

3.3.2 Эрсдэл: Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулга буруу илэрхийлэгдэх, холбогдох заавар, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж: Мөнгөн кассын тооллого сар бүр хийж хэвших.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт: Газар ивээл ТӨААҮГ нь 2 автомашинтай бөгөөд тухайн автомашинуудад техник ашиглалтын паспорт хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцээгүй.

3.4.2 Эрсдэл: Сэлбэг хэрэгсэл болон засвар үйлчилгээнд бүртгэлээр тавих хяналт алдагдах, анхан шатны баримт, бүртгэлийг хөтлөөгүй байх;

3.4.3 Өгсөн зөвлөмж: Бүх авто машиндаа техник ашиглалтын паспортыг хөтөлж, хувийн хэрэг нээн сэлбэгийн болон шатахууны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Зардлын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт: 2019 оны 1-р сараас 6-р сар хүртэл шатахууны тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтын бүрэн хэрэгжүүлээгүй.

3.5.2 Эрсдэл: Төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулах, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж: Шатахууны тайланг үнэн зөв гаргаж, хэтрэлт хэмнэлтийг тооцож ажиллаж

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг мөрдөн ажиллана

3.6 Зардлын данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт: Туршилтын болон загварын бүтээгдэхүүний тайлан гаргаж, тооцоо бодоогүй, бүртгэл хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.6.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан толилуулга буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3.6.3 Өгсөн зөвлөмж: Туршилтын болон загварын бүтээгдэхүүний тайланг тогтмол цаг хугацаанд нь хөтөлж хэвших.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.7 Зардлын данстай холбоотой асуудал

3.7.1 Илрүүлэлт: Шилэн дансны мэдээлэлд 3 бүртгэл хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцээгүй.

3.7.2 Эрсдэл: Мэдээллийг хэрэглэгчдэд цаг хугацаанд хүргэхгүй байх эрсдэлтэй.

3.7.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх.

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг мөрдөн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,406,361.63	159,128,781.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	69,585,389.91	126,946,213.82
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	116,310.00	194,920.00
31110	Төгрөг	116,310.00	194,920.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	69,469,079.91	126,751,293.82
3121	Төгрөг	69,469,079.91	126,751,293.82
31213	Арилжааны банк дахь харилцах	69,469,079.91	126,751,293.82
3122	Гадаад валют	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
33	АВЛАГА	224,996.21	921,662.77
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
3471	Урьдчилгаа тооцоо	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,595,975.51	31,260,904.62
351	Түүхий эд материал	0.00	0.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	4,200,185.69	1,857,741.45
354	Хангамжийн материал	22,395,789.82	29,403,163.17
35470	Бусад хангамжийн материал	22,395,789.82	29,403,163.17
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	265,531,494.46	220,975,581.55
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	265,531,494.46	220,975,581.55
391	Газар		
392	Биет хөрөнгө	263,673,174.03	220,004,799.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,720,000.00	31,720,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,991,666.60	-14,928,333.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	277,404,889.00	277,404,889.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,828,576.31	-88,628,404.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,924,625.14	10,924,625.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,415,291.20	-2,898,457.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,859,194.00	6,410,480.00
393	Биет бус хөрөнгө	1,858,320.43	970,781.95
39301	Програм хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,579,371.88	-3,466,910.36
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	361,937,856.09	380,104,362.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	361,937,856.09	380,104,362.76
51	Засгийн газрын хувь оролцоо	361,937,856.09	380,104,362.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,504,839.33	211,504,839.33
51101	Өмч: - төрийн	211,504,839.33	211,504,839.33
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	150,433,016.76	168,599,523.43
51210	Өмнөх үеийн үр дүн	150,433,016.76	150,433,016.76
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	18,166,506.67
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	361,937,856.09	380,104,362.76

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,097,096,655.47	205,375,227.49
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,097,096,655.47	205,375,227.49
120	Нийтлэг татварын бус орлого	1,097,096,655.47	205,375,227.49
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	1,389,874.29	470,064.48
120003	Торгуулийн орлого		
120009	Бусад орлого		
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	630,913,181.76	736,227,727.34
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	464,793,599.42	-531,322,564.33
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	111,333,913.41	189,069,706.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,333,913.41	189,069,706.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,333,913.41	89,069,706.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,333,913.41	89,069,706.82
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	49,536,630.83	76,146,871.20
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/		
210813	Бусад зардал /ТӨҮГ/		
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	11,797,282.58	12,922,835.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,000,000.00	100,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,000,000.00	100,000,000.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,000,000.00	100,000,000.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	985,762,742.06	16,305,520.67
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	202,440,719.77	1,860,986.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	202,440,719.77	1,860,986.00
145003	Хөрөнгө оруулалтын олз		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	202,440,719.77	1,860,986.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,188,203,461.83	18,166,506.67

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	799,607,442.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	799,457,442.00
110	Орлогын албан татвар	0.00	799,457,442.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.00	799,457,442.00
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		
110002	Үйл ажиллагааны орлого		799,457,442.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	150,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	150,000.00
120009	Бусад орлого		150,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/		
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/		
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/		
120016	Буцаан авсан албан татвар /ТӨҮГ/		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	194,931,657.90	642,725,659.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	194,931,657.90	642,725,659.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194,931,657.90	642,725,659.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,870,971.55	135,592,777.47
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	115,870,971.55	135,592,777.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	976,758.28	1,425,696.94
210205	Эрүүл мэндийн даатгал		
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	976,758.28	1,425,696.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	329,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		329,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,827,500.00	437,991,315.21
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		7,064,800.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	5,827,500.00	430,926,515.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,256,428.07	67,386,869.43
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	57,708,033.07	56,777,759.43
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	0.00	224,532.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	14,548,395.00	10,384,578.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-194,931,657.90	156,881,782.95
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	19,235,974.29	56,479,040.96

140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	17,846,100.00	56,008,976.48
140004	Хөрөнгө оруулалтын олз		
140005	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
140006	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
140007	Хүлээн авсан хүүний орлого	1,389,874.29	470,064.48
140008	Хүлээн авсан ногдол ашиг		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	17,836,100.00	56,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,836,100.00	56,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,836,100.00	56,000,000.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	17,836,100.00	56,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>1,399,874.29</u>	<u>479,040.96</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	50,000,000.00	-100,000,000.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	50,000,000.00	-100,000,000.00
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
250005	Төлсөн ногдол ашиг		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>50,000,000.00</u>	<u>-100,000,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-143,531,783.61	57,360,823.91
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,353,116.52	69,585,389.91
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	69,585,389.91	126,946,213.82


4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,570,029.00		209,570,029.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,570,029.00	0.00	209,570,029.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн		152,367,827.09	152,367,827.09
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,570,029.00	152,367,827.09	361,937,856.09
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,570,029.00	152,367,827.09	361,937,856.09
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D07	Тайлант үеийн үр дүн		18,166,506.67	18,166,506.67
D08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,570,029.00	170,534,333.76	380,104,362.76

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	НБББББ нь тухайн байгууллагын өөрийн онцлогт тохироогүй, үйл ажиллагаатай уялдаагүй.	-	Зөвлөмж өгөх	Нягтлаг бодогч	Н.Базаррагчаа
2	Сар бүр эсгүүрийн цехээс оёдлын цехэд, оёдлын цехээс бэлэн бүтээгдэхүүний тасагт шилжсэн үйлдвэрлэлийн дамжлагын бүртгэл хөтөлж, тайлан гаргаагүй.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н.Базаррагчаа
3	Мөнгөн кассын тайлангийн үлдэгдлийн тооллого сар бүр хийгээгүй	0,3	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н.Базаррагчаа
4	Газар ивээл” ТӨААҮГ нь 2 автомашинтай бөгөөд тухайн автомашинуудад техник ашиглалтын паспорт хөтлөөгүй	1,5	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н.Базаррагчаа
5	2019 оны 1-р сараас 6-р сар хүртэл шатахууны тооцоо бодоогүй	0,5	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н.Базаррагчаа
6	Туршилтын болон загварын бүтээгдэхүүний тайлан гаргаж, тооцоо бодоогүй бодож бүртгэл хөтлөөгүй	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н.Базаррагчаа
7	Шилэн дансны 3 мэдээлэл хугацаа хоцроосон.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н.Базаррагчаа
	Нийт дүн	2.3			

